



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/547

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "г", Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.2, 40.2.4, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.20, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хэлний тухай хууль, Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс ирүүлсэн чиглэл, Эх хэлний салбар зөвлөлийн 2021 оны төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан "Хичээнгүй сайхан бичиг" бүтээлийн уралдаанд зориулан 550,000 (Таван зуун тавин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012500

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 сарын
19-ний өдрийн А/547 тоот захирамжийн
хавсралт



"Сайхан бичигтэн-2021" шагналын төсөв

№	Бараа материал	тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөл	10	5000	50000
2	Шилдэг бүтээл /мөнгөн шагнал/	5	50000	250000
3	Онцлох бүтээл /мөнгөн шагнал/	5	30000	150000
4	Зохион байгуулалтын бичиг хэргийн зардал	1	100000	100000
Нийт				550000